

**ДЭЛХИЙН СОЁЛЫН БОЛОН
БАЙГАЛИЙН ӨВИЙГ
ХАМГААЛАХ КОНВЕНЦ
(1972)**

Нэгдсэн Үндэстний Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллага /ЮНЕСКО/-ын Ерөнхий бага хурал 1972 оны 10 дугаар сарын 17-ноос 11 дүгээр сарын 21-нд Парис хотноо чуулсан 17 дугаар чуулганаараа,

- Соёлын болон байгалийн өв зөвхөн аяндаа эвдэрч гэмтэхээс гадна нийгэм эдийн засгийн амьдралын хувьсал өөрчлөлтийг дагалдан гарч буй хор хөнөөл, эвдрэл сүйрлийн улмаас устаж үгүй болох аюул улам бүр заналхийлж байгааг тэмдэглэн,
- Соёлын болон байгалийн аливаа үнэт өвийг эвдэн сүйтгэж, устгах нь дэлхийн улс түмний нийтийн хөрөнгө баялгийг туйлын хомсдуулж байгаа хэрэг гэж үзээд,
- Хамгаалвал зохих баялаг бүхий улс орны эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн нөөц бололцоо хүрэлцээгүйн улмаас уг өвийг үндэсний хэмжээнд хамгаалах арга зам ихэнхдээ хангалтгүй байдаг гэж үзээд,
- Хүн төрөлхтний нийтийн өвийг хадгалах, хам гаалах тухай ойлголтыг сурталчлах, өргөтгөх, хадгалахад туслах, мөн сонирхогч улсуудын хооронд олон улсын холбогдох Конвенц байгуулахыг зөвлөх зэрэг асуудлыг Байгууллагын дүрэмд тусгасан байдгийг сануулаад,
- Юугаар ч орлуулшгүй, ховор нандин баялгийг ямар ард түмэн эзэмшиж байгаагаас үл шалтгаалан дэлхийн бүх улс түмэн хамгаалахын чухлыг соёлын болон байгалийн баялгийн талаар байгуулсан олон увын конвенц, зөвлөмж, тогтоолд тусгасан гэж үзээд,
- Соёлын болон байгалийн өвийн зарим баялаг нь гойд сонирхол татдаг учраас тэднийг нийт хүн төрөлхтний өвийн бүрэлдэхүүн хэсэг хэмээн үзэж хамгаалах шаардлагатайг анхааруулаад,
- Байгалийн болон соёлын өвд учрах аюул улам ноцтой болж байгаатай уялдан олон улсын хамтын нийгэмлэг үнэт баялаг бүхий сонирхогч орнуудын үйл ажиллагааг хязгуурлахгүйгээр байгалийн болон соёлын өвийг хамгаалахад заавал оролцож хамтарсан үйл ажиллагаа явуулах нь илүү үр ашигтай болно гэж үзээд,
- Энэ зорилгоор орчин үеийн шинжлэх ухааны аргад үндэслэн нэрд гарсан дэлхий дахины ач холбогдолтой байгалийн болон соёлын өвийг нийтээр хамгаалах үр ашигтай систем тогтоох талаар хэлэлцэн тохиролцсон шинэ дүрэм боловсруулах нь зайлшгүй чухал гэж үзээд,
- Энэ асуудлаар олон улсын конвенц байгуулахаар 16 дугаар чуулганаар шийдвэрлэсэн учир, 1972 оны 11 дүгээр сарын 16-нд энэхүү Конвенцийг батлав.

Нэг. Соёлын болон байгалийн өвийн тодорхойлолт

Нэгдүгээр зүйл

Энэхүү Конвенцид “Соёлын өв” гэдэг ойлголтод:

- Хөшөө дурсгалууд: түүх, урлаг, шинжлэх ухааны хувьд дэлхий нийтийн хосгүй гайхамшигт үнэ цэнэ бүхий уран барилга, сүрлэг чимэглэлийн уран баримал, уран зургийн бүтээл, археологийн олдворууд, бичээс, агуй болон цогцолбор дурсгалууд,

- Уран барилгын чуулган: түүх, урлаг, шинжлэх ухааны хувьд дэлхий нийтийн хосгүй гайхамшигт үнэ цэнэ бүхий салангид буюу нэгдмэл барилга байгууламж уран барилгуудын цогцолбор,
- Түүхийн дурсгалт газрууд: хүний болон хүн, байгалийн хамтарсан бүтээлүүд мөн түүх, гоо зүй, угсаатны судлалын хувьд дэлхий нийтийн хосгүй гайхамшигт үнэ цэнэ бүхий археологи, түүхийн дурсгалт газрыг багтаасан бүс нутгийг оруулна.

Хоёрдугаар зүйл

Энэхүү конвенцид “Байгалийн өв” гэдэг ойлголтод:

- Байгалийн болон биологийн хүчин зүйлийн нөлөөгөөр бүрэлдэн тогтсон, гоо зүй, шинжлэх ухааны үүднээс дэлхий нийтийн хосгүй гайхамшигт үнэ цэнэ бүхий хэсэг бүлэг байгалийн дурсгал,
- Геологи болон физик газарзүйн бүтцийн хувьд шинжлэх ухааны болон хадгалалтын дэлхий нийтийн хосгүй гайхамшигт үнэ цэнэ бүхий сүйрэх аюулд өртсөн амьтан, ургамлын төрөл зүйл бүхий тодорхой тогтоосон бүс нутаг,
- Хадгалагдсан байдал болон байгалийн үзэсгэлэн, шинжлэх ухааны хувьд хосгүй гайхамшигт үнэ цэнэ бүхий байгалийн дурсгалт газар болон тодорхой тогтоосон бүс нутгийг оруулна.

Гуравдугаар зүйл

Энэхүү Конвенцид нэгдэн орсон орон бүр өөрийн нутаг дэвсгэрт байгаа өвийг дээр дурдсан 1, 2 дугаар зүйлийн дагуу тодорхойлж, зааглавал зохино.

Хоёр. Соёлын болон байгалийн өвийн үндэсний болоод олон улсын хамгаалалт

Дөрөвдүгээр зүйл

Энэхүү Конвенцид нэгдсэн орон бүр юуны өмнө өөрийн нутаг дэвсгэрт байгаа дээр дурдсан 1, 2 дугаар зүйлд заасан соёлын болон байгалийн өвийг илрүүлэх, хамгаалах, хадгалах, сурталчлах төдийгүй хойч үедэ өвлүүлэн өгөх үүрэг ногдож байгааг хүлээн зөвшөөрч байна. Энэ зорилгын үүднээс, тухайн орон байгаа нөөцийг дээд хэмжээгээр ашиглахад өөрийн хүчийг дайчлан, шаадлагатай тохиолдолд олон улсын тусламж, хамтын ажиллагааны хэлбэрүүд, тухайлбал санхүү урлаг, шинжлэх ухаан техникийн харилцааг ашиглан үйл ажиллагаа явуулахыг эрмэлзэнэ.

Тавдугаар зүйл

Энэхүү Конвенцид нэгдэн орсон орон бүр өөрийн нутаг дэвсгэрт байгаа соёлын болон байгалийн өвийг аль болох үр ашигтай хамгаалах, хадгалах, идэвхтэй сурталчлах боломжийг хангах үүднээс өөрийн орны нөхцөлд тохирсон арга хэмжээг бололцоогоороо авахын тулд:

а) соёлын болон байгалийн өвийг нийгмийн амьдралд тодорхой үүрэгтэй болгох, уг өвийг хамгаалах ажлыг ерөнхий төлөвлөлтийн хөтөлбөрт тусгахад чиглэсэн нийтлэг бодлого явуулах,

б) соёлын болон байгалийн өвийг хамгаалах, хадгалах, сурталчлахад шаардагдах зохих мэргэжилтэн, хөрөнгө, хэрэгслээр хангагдсан нэг буюу хэд хэдэн албадыг одоохондоо байгуулж амжаагүй байгаа орнууд шинээр байгуулах,

в) тухайн орон соёлын болон байгалийн өвдөө учирч буй аюулыг арилгах ажлын арга барилыг төгөлдөржүүлэх, шинжлэх ухаан техникийн шинжилгээ судалгааг хөгжүүлэх,

г) соёлын болон байгалийн өвийг хамгаалах, хадгалах, сурталчлахад бэлтгэх, энэ салбарт шинжлэх ухааны судалгааг өргөжүүлэх үндэсний ба бүс нутгийн өвийг байгуулж хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх,

д) соёлын болон байгалийн өвийг хамгаалах, хадгалах, сурталчлахад бэлтгэх, энэ салбарт шинжлэх ухааны суалгааг өргөжүүлэх үндэсний ба бүс нутгийн өвийг байгуулж хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

Зургадугаар зүйл

1. Нутаг дэвсгэртээ 1, 2 дугаар зүйлд тодорхойлсон байгалийн болон соёлын өв бүхий улс орны бие даасан эрхийг бүрэн хүндэтгэж уг өвтэй харьцах үндэсний хууль зүйн эрхэд харшлахгүйгээр эдгээр бүх нийтийн өвийг болон улсын байгууллагатай хамтран хамгаалах үүрэгтэйг энэхүү Конвенцид нэгдсэн орнууд хүлээн зөвшөөрч байна.

2. Нутаг дэвсгэртээ 11 дүгээр зүйлийн 2, 4 дүгээр заалтад дурдсан байгалийн болон соёлын өв бүхий орнууд уг өвийг илрүүлэх, хамгаалах, хадгалах, сурталчлах талаар тусламж үзүүлэхийг хэрэв хүсвэл Конвенцид нэгдсэн орнууд энэхүү Конвенцийн дагуу дэмжлэг үзүүлэх үүрэг хүлээнэ.

3. Энэхүү Конвенцид нэгдэн орсон орон бүр конвенцид нэгдсэн бусад орны нутаг дэвсгэрт байгаа 1, 2 дугаар зүйлд тодорхойлсон байгалийн болон соёлын өвд шууд буюу дамаар хохирол учруулж болох ямар нэг үйл явууллага санаатайгаар үйлдэхгүй байх үүрэг хүлээнэ.

Долдугаар зүйл

Энэхүү Конвенцид дурдсан дэлхийн соёлын болон байгалийг өвийн олон улсын хамгаалалт гэдэг нь тэрхүү өвийг хадгалах, тодруулахад чиглэсэн Конвенцид оролцогч улсуудын хүчин чармайлтад тус дэмжлэг үзүүлэх олон улсын хамтын ажиллагаа, тусламжийн систем байгуулахыг хэлнэ.

Гурав. Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах засгийн газар хоорондын хороо

Наймдугаар зүйл

1. Нэрд гарсан үнэт ач холбогол бүхий байгалийн болон соёлын өвийг хамгаалах Засгийн газар хоорондын хороог “Дэлхийн өвийн хороо” нэртэйгэр Нэгдсэн Үндэстний Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллагын дэргэд байгуулав. Уг Хороо нь Нэгдсэн Үндэстний Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллагын Ерөнхий бага хурлын ээлжит чуулганаас сонгосон Конвенцид нэгдсэн 15 улсаас бүрдэнэ. Хорооны бүрэлдэхүүнд орох орнуудын тоо энэхүү Конвенц 40-өөс цөөнгүй орныг нэгтгэж хүчин төгөлдөр болсны дараа хуралдах Ерөнхий бага хурлын ээлжит чуулганаас эхлэн 21 хүртэл өсч болно.

2. Хорооны гишүүдийг дэлхийн янз бүрийн бүс нутаг, соёлыг тэгш эрхтэй төлөөлөх зарчмыг хангах үндсэн дээр сонгоно.

3. Нэгдсэн Үндэстний Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллагын Ерөнхий бага хурлын ээлжит чуулганы үеэр хуралдах Конвенцид нэгдсэн орнуудын Ерөнхий ассамблейн хүсэлтийг харгалзан Соёлын дурсгалыг сэргээн засварлах, хадгалах Олон улсын судалгааны төв (Ромын төв), Хөшөө дурсгал, дурсгалт газрыг хамгаалах олон улсын зөвлөл (ИКОМОС), Байгалийн баялаг, байгаль орчныг хамгаалах олон улсын холбоо, мөн тэдэнтэй ижил зорилго бүхий засгийн газар хоорондын болон хуралдаанд зөвлөх эрхтэйгээр оролцож болно.

Есдүгээр зүйл

1. Дэлхийн өвийн хорооны гишүүн орнууд тэднийг сонгосон Ерөнхий бага хурлын ээлжит чуулганаас эхлэн түүний дараачийн 3 дахь ээлжит чуулганыг дуустал бүрэн эрхээ эдэлнэ.

2. Анхны сонгуулиар сонгогдсон гишүүдийн гуравны нэгийн бүрэн эрхийн хугацаа тэднийг сонгосон чуулганы дараах Ерөнхий бага хурлын анхны ээлжит чуулганы эцэст дуусах бөгөөд гуравны хоёрын бүрэн эрхийн хугацаа тэднийг сонгосон чуулганы дараах Ерөнхий бага хурлын ээлжит хоёрдугаар чуулганаар дуусна. Хорооны эдгээр гишүүдийн нэрсийг эхний сонгуулийн дараа Нэгдсэн Үндэстний Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллагын Ерөнхий бага хурлын дарга сугалаагаар тодорхойлно.

3. Хорооны гишүүн орнууд болон байгалийн өвийн салбарт нэр хүндтэй хүмүүсийг өөрийн төлөөлөгчөөр сонгон дэвшүүлнэ.

Аравдугаар зүйл

1. Дэлхийн өвийн хороо дотоод журмаа батална.

2. Хороо тусгай асуудлаар зөвлөлдөх зорилгоор олон нийтийн болон хувийн байгууллагууд, түүнчлэн хувь хүмүүсийг аль ч үед хуралдаа урин оролцуулж болно.

3. Хэрэв шаарлагатай гэж үзвэл үүрэгтэ ажлаа гүйцэтгэхийн тулд Хороо Зөвлөлдөх байгууллагууд байгуулж болно.

Арван нэгдүгээр зүйл

1. Энэхүү Конвенцид нэгдсэн орон бүр нутаг дэвсгэртээ байгаа бөгөөд энэ зүйлийн 2 дугаар заалтад оруулж болох соёлын болон байгалийн өвийн үнэт зүйлийн жагсаалтыг Дэлхийн өвийн хороонд бололцооныхоо хирээр гаргаж өгнө. Бүрэн төгс гэж үзэж болохгүй энэхүү жагсаалтад: тухайн үнэт зүйлийн оршиж байгаа газар нутгийн талаар болон холбогдох бусад баримт бичгүүд багтах ёстой.

2. Нэгдүгээр заалтын дагуу улс орнуудын гаргаж өгсөн жагсаалтыг үндэслэн энэхүү Конвенцийн 1, 2 дугаар зүйлд тодорхойлсон бөгөөд Хорооны үзэж байгаагаар нэрд гарсан тал бүрийн үнэт соёлын болон байгалийн өвийн жагсаалтыг тогтоосон шалгуурын дагуу тус Хорооноос 2 жилд 1 удаа “Дэлхийн өвийн жагсаалт” гэсэн нэртэйгээр хэвлэн гаргаж байна. Жагсаалтыг хоёр жилд нэгээс доошгүй шинэчлэн тараана.

3. Конвенцид нэгдсэн-сонирхогч улсын зөвшөөрөлгүйгээр “Дэлхийн өвийн Жагсаалт”-д үнэт зүйлийг оруулахгүй. Бүрэн эрх буюу шүүн таслах эрхийн талаар хэд хэдэн улс маргалдаж буй нутаг дэвсгэр дээр байгаа үнэт зүйлийг жагсаалтад оруулах нь маргалдагч талуудын эрхэнд хэрхэвч харшлахгүй.

4. Хороо шаардлагатай үед энэхүү Конвенцийн хүрээнд тусламж хүссэн Дэлхийн өвийн жагсаалтад орсон бөгөөд авран хамгаалах нь үлэмж ажил шаардагдаж байгаа үнэт зүйлийн жагсаалтыг “Дэлхийн аюулд нэрвэгдэж буй өвийн жагсаалт” гэсэн нэртэйгээр гаргаж, шинэчлэн хэвлэж байна. Энэ тусламжинд шаардагдах барагцаалсан үнийг заана. Энэхүү жагсаалтад зөвхөн тодорхой, ноцтой аюулд учирсан, тухайлбал хурдан даамжрах, эвдрэлийн улмаас учирсан сүйрэх аюултай аюул, олон нийтийн буюу хувийн томоохон ажил гүйцэтгэгч төсөл, хот, жуулчлалын хурдан хөгжил, газрын зориулалт буюу газар өмчлөх эрхийн өөрчлөлттэй холбогдон гарсан эвдрэл, үл мэдэгдэх шалтгааны улмаас гарсан томоохон эвдрэл, ямар нэг шалтгаанаар хаягдаж эзгүйрэх, байгалийн гай гамшиг, эрс эргэлт, зэвсэгт мөргөлдөөний аюул, их гал түймэр, газар хөдлөлт, суулт, галт уулын дэлбэрэлт, үер, тэнгис далайн түрэлт зэргийн улмаас аюулд учирсан соёлын болон байгалийн өв орно. Хороо онцгой тохиолдолд шинээр аюулд нэрвэгдэж буй үнэт зүйлийг дэлхийн өвийн жагсаалтад ямар ч үед оруулж болох бөгөөд энэ тухайгаа даруй мэдэгдэнэ.

5. Хороо энэ зүйлийн 2, 4-т дурдсан хоёр жагсаалтад оруулж болох соёлын болон байгалийн өвийн шалгуурыг тодорхойлно.

6. Хороо энэ зүйлийн 2, 4-т дурдсан хоёр жагсаалтын аль нэгд үнэт зүйлийг оруулахгүй тухай эцсийн шийдвэр гаргахын өмнө соёлын болон байгалийн өв бүхий Конвенцид нэгдэгч улсуудтай зөвлөлдөнө.

7. Хороо энэхүү зүйлийн 2, 3-т дурдсан жагсаалтыг гаргахын тулд шаардагдах судалгаа, шижилгээ явуулах ажлыг сонирхогч улсуудтай тохиролцсоны дагуу зохицуулж дэмжинэ.

Арван хоёрдугаар зүйл

Соёлын болон байгалийн өвийн ямар нэг үнэт зүйл нь 11 дүгээр зүйлийн 2, 4-т дурдсан хоёр жагсаалтын аль нэгд ороогүй явдал уг үнэт зүйл хосгүй гайхамшигт үнэ цэнэгүй гэсэн хэрэг биш бөгөөд тэдгээрийг жагсаалтад оруулахгүй гэснээс өөр зорилгогүй юм.

Арван гуравдугаар зүйл

1. Конвенцид нэгдсэн 11 дүгээр зүйлийн 2, 4-т дурдсан жагсаалтуудад орсон буюу орж болох соёлын болон байгалийн өв бүхий орнууд уг өвтэй холбогдуулан олон улсын тусламж авах тухай гаргасан хүсэлтийг Дэлийн өвийн хороо нь хүлээн авч судална. Тийм хүсэлт нь үнэт зүйлийг хамгаалах, хадгалах, сурталчлах буюу сэргээн засварлахад чиглэж болно.

2. Энэхүү зүйлийн 1-д заасны дагуу олон улсын тусламж авах тухай хүсэлт нь урьдчилсан судалгаа, шинжилгээний дүн, цаашид судалгаа шинжилгээ хийх шаардлагатай гэдгийг нотолсон тохиолдолд 1, 2 дугаар зүйлд тодорхойлсон соёлын болон байгалийн өвийг илрүүлэхэд холбогдсон байж болох юм.

3. Хороо нь тэдгээрийн хүсэлтийг авч үзээд шийдвэр шаардлагатай үед тусламжийнхаа шинж чанар, хэмжээг тодорхойлсон сонирхогч засгийн газартай зохих гэрээ хэлэлцээр байгуулахыг зөвшөөрнө.

4. Хороо нь өөрийн үйл ажиллагаанд дарааллын журам тогтооно. Ийнхүү дараалал тогтоохдоо хамгаалалт шаардагдаж буй дэлхийн соёлын болон байгалийн өвийн ач холбогдол, байгаль, суут ухаан, дэлхийн улс түмний түүхийн үлэмж үнэт зүйлд олон улсын хамгаалалтыг хангах шаардлага, хийх шаардлагатай ажлын зайлшгүй байдал, нутаг дэвсгэртээ үнэт зүйл бүхий улс орны нөөц бололцоо, тухайлбал тэдгээр үнэт зүйлийг өөрийн хүчээр хамгаалах тухайн улс орны хүчин чадлыг харгалзан үзнэ.

5. Хороо нь олон улсын тусламж үзүүлэхээр тогтоосон үнэт зүйлийн жагсаалтыг гаргаж, шинэчлэн тарааж байна.

6. Хороо нь энэхүү Конвенцийн 15 дугаар зүйлд заасны дагуу байгуулагдсан сангийн хөрөнгийг ашиглах тухай шийдвэр гаргаж байна. Мөн уг хөрөнгийг нэмэгдүүлэх арга зам хайх, үүнтэй холбогдуулан шаардлагатай бүхий л арга хэмжээ авч байна.

7. Хороо нь энэхүү Конвенцийн зорилготой ижил зорилго бүхий олон улсын болон засгийн газрын, засгийн газрын бус байгууллагуудтай хамтран ажиллана. Хороо өөрийн хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлэх зорилгоор өөр байгууллагууд, тухайлбал Соёлын үнэт зүйлийг хадгалах, сэргээн засварлах олон улсын судалгааны төв (Ромын

төв), Хөшөө дурсгал ба дурсгалт газрыг хамгаалах олон улсын зөвлөл (ИКОМОС), Байгаль, байгалийн баялгийг хамгаалах олон улсын холбоо (МСОП) түүнчлэн төрийн болон хувийн байгууллагууд, хувь хүмүүсээс тусламж хүсч болно.

8. Хороо санал хураахад оролцож байгаа Хорооны гишүүдийн гуравны хоёрын саналаар шийдвэр гаргана. Хорооны гишүүдийн олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно.

Арван дөрөвдүгээр зүйл

1. Нэгдсэн Үндэстний Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллагын Ерөнхий Захирлын томилсон Нарийн бичгийн дарга нарын газар Дэлхийн өвийн хороонд тусална.

2. Нэгдсэн Үндэстний Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллагын Ерөнхий Захирал Соёлын үнэт зүйлийг хадгалах, сэргээн засварлах олон улсын судалгааны төв (Ромын төв), Хөшөө дурсгал ба дурсгалт газрыг хамгаалах олон улсын зөвлөл (ИКОМОС), Байгаль, байгалийн баялгийг хамгаалах олон улсын холбоо (МСОП)-ны эрх мэдэл болон зохих боломжийнх нь хүрээнд тэдний тусламж дэмжлэгийг дээд зэргээр ашиглан тус Хорооны баримт бичиг, хурлын хэлэлцэх асуудлыг бэлтгэх, түүний шийдвэрийг хэрэгжүүлэх явцыг хангана.

Дөрөв. Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах сан

Арван тавдугаар зүйл

1. “Дэлхийн өвийн сан” гэж нэрлэгдэх дэлхий нийтийн хосгүй гайхамшигт үнэ цэнэ бүхий дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах сан үүгээр байгуулагдаж байна.

2. Нэгдсэн Үндэстний Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллагын санхүүгийн тухай журмын холбогдох зүйл ёсоор тус сан нь итгэмжлэгдсэн сан болно.

3. Тус сангийн хөрөнгө нь:

а) энэхүү Конвенцид Оролцогч Улсуудын албан татвар, сайн дурын хандив,

б) дор дурдсан хандив, бэлэг, гэрээсэлсэн хөрөнгө

1. Бусад орны,
2. Нэгдсэн Үндэстний Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллага, НҮБ-ын системийн бусад байгууллагууд, тухайлбал, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр болон бусад засгийн газар хоорондын байгууллагын,
3. Төрийн ба хувийн байгууллагууд болон хувь хүмүүсийн өгсөн хандив, бэлэг, гэрээсэлсэн өв хөрөнгө,

в) сангаас зээлээр олгосон мөнгөний хүү,

г) олон улсын санд зориулан зохион байгуулсан арга хэмжээнээс гаргасан хуримтлал болон орлогын мөнгө,

д) түүнчлэн Дэлхийн өвийн хорооны боловсруулан сангийн тухай заалтын дагуу батлагдсан бусад аливаа хөрөнгөөс бүрдэнэ.

4. Санд оруулж буй хандив болон Хороонд үзүүлж буй тусламжийн бусад хэлбэр нь зөвхөн Хорооны тодорхойлсон зорилгод ашиглагдана. Тодорхой төлөвлөгөө буюу төслийг хэрэгжүүлэхийн тулд тэдгээрийг хэрэгжүүлэх нөхцөлтэйгээр түүнд зориулсан татвар хандивыг Хороо авч болно.

5. Санд оруулах татвар, хандив нь ямар нэг улс төрийн нөхцөл болзолгүй байна.

Арван зурагдугаар зүйл

1. Нэгдсэн Үндэстний Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллагын Ерөнхий бага хурлын чуулганы үед хуралдах Конвенцид нэгдсэн орнуудын Ерөнхий Ассамблейгаар бүх улсуудад адил хувиар тогтоосон татварыг аливаа сайн дурын нэмэгдэл хандивтаа хохирол учруулахгүйгээр Дэлхийн өвийн санд хоёр жилд нэг удаа тогтмол төлөх үүрэг хүлээнэ. Ерөнхий Ассамблейн энэ шийдвэрийг энэхүү зүйлийн 2-т заасан мэдэгдлийг хийгээгүй, санал хураалтад оролцсон Конвенцид нэгдсэн улсуудын олонхийн саналаар батална.

Конвенцид нэгдсэн улсуудын татвар нь тэднээс Нэгдсэн Үндэстний Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллагад төлдөг татварын нэг хувиас хэтэрч болохгүй.

2. Гэхдээ энэхүү Конвенцийн 31 буюу 32 дугаар зүйлд дурдсанаар улс бүр батламж жуух бичиг, батлах буюу элсэх тухай баримт бичгээ гардуулах үедээ тэрээр энэ зүйлийн 1 дүгээр заалтын дагуу үүрэг хүлээхгүй гэдгээ мэдэгдэж болно.

3. Энэ зүйлийн 2-т заасан мэдэгдэл хийсэн Конвенцид нэгдэгч улс Нэгдсэн Үндэстний Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллагын Ерөнхий Захиралд ямар ч үед мэдэгдэл өгч дээр дурдсан мэдэгдлээсээ няцаж болно. Гэвч энэхүү татгалзсан мэдэгдэл нь Конвенцид нэгдсэн орнуудын дараагийн ээлжит Ерөнхий Ассамблейн чуулсан өдрөөс эхлэн тухайн улсын татварт нөлөөлөх болно.

4. Хороо үйл ажиллагаагаа үр ашигтай төлөвлөсөн байхын тулд энэхүү зүйлийн 2-т заасан мэдэгдэл хийсэн Конвенцид нэгдсэн орнууд энэхүү зүйлийн 1 дүгээр заалттай холбогдсон тохиолдолд төлөх ёстой татварын хэмжээнээс багагүй татварыг тогтмол үндэсэн дээр наад зах нь хоёр жилд нэг удаа төлнө.

5. Тухайн жилийн буюу урьдах жилүүдийн албан ёсны буюу сайн дурын татвараа төлөөгүй байгаа Конвенцид нэгдсэн аль ч улс нь Дэлхийн өвийн сангийн

Хорооны гишүүнээр сонгогдож чадахгүй. Гэхдээ энэ заалт нь анхны сонгуулийн үед хамаарахгүй. Хороын гишүүн ийм улсын бүрэн эрх нь энэхүү Конвенцийн 8 дугаар зүйлийн 1-д заасан сонгуулийн үед дуусна.

Арван долдугаар зүйл

Энэхүү Конвенцид нэгдэгч орнууд Конвенцийн 1, 2 дугаар зүйлд тодорхойлсон соёлын болон байгалийн өвийг хамгаалах аливаа хүчийн чармайлтыг хөхиүлэн дэмжих зорилго бүхий улсын, хувийн, үндэсний сан буюу эсвэл холбоог байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

Арван наймдугаар зүйл

Энэхүү Конвенцид нэгдэгч орнууд Нэгдсэн Үндэстний Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллагын ивээл дор зохиогдож байгаа Дэлхийн өвийн санд зориулсан хөрөнгө цуглуулах олон улсын хөдөлгөөнд тусламж дэмжлэг үзүүлнэ.

Тав. Олон улсын тусламж үзүүлэх нөхцөл, хэлбэрүүд

Арван есдүгээр зүйл

Энэхүү Конвенцид нэгдсэн аль ч улс өөрийн нутаг дэвсгэрт байгаа дэлхий нийтийн хосгүй гайхамшигт үнэ цэнэ бүхий соёлын болон байгалийн өвд зориулан олон улсын тусламж хүсч болно. Хүсэлт тавихдаа Конвенцийн 21 дүгээр зүйлийн дагуу Хорооны шийдвэр гаргахад шаардагдах мэдээлэл болон баримт бичгийг хавсаргана.

Хорьдугаар зүйл

Олон улсын тусламжийг Дэлхийн өвийн хорооноос зөвхөн 11 дүгээр зүйлийн 2, 4-т дурдсан жагсаалтуудын аль нэгд оруулахаар шийдсэн буюу шийдэж байгаа соёлын болон байгалийн өвд зориулж энэхүү Конвенцийн 13 дугаар зүйлийн 2, 22 дугаар зүйлийн (в) болон 23 дугаар зүйлийн дагуу олгоно.

Хорин нэгдүгээр зүйл

1. Дэлхийн өвийн хороо олон улсын тусламж үзүүлэхийг хүссэн хүсэлтэд ямар элементүүдийг агуулагдах ёстойг тухайлбал, авч явуулах үйл ажиллагааны цар хүрээ, шаардагдах ажил, түүний багцаалсан үнэ, яаралтай байдал, тусламж хүссэн улс зохих зардлыг дангаараа гаргаж чадахгүй байгаа шалтгааныг тодорхой заасан журмыг тодорхойлно. Хүсэлтүүд нь боломжтой бол мэргэжилтнүүдийн дүгнэлтийг тухай бүр хавсаргасан байх ёстой.

2. Сүйрэл, байгалийн гай гамшигтай холбогдуулан тусламж авахыг хүссэн хүсэлтийг Хороо хэрэгжүүлж болохуйц яаралтай хэрэгжүүлэх шаардлагатай ажил гэж

үзвэл түүнийг тэргүүн ээлжинд авч үзэх ёстой бөгөөд Хороо ийм тохиолдолд олгох нөөц сантай байх ёстой.

3. Хороо шаардлагатай гэж үзвэл тийм шийдвэр гаргахын өмнө судалгаа буюу зөвлөлгөөн хийж болно.

Хорин хоёрдугаар зүйл

Дэлхийн өвийн хорооны олгох тусламж нь дараах хэлбэртэй байж болно. Үүнд:

- а) Энэхүү Конвенцийн 11 дүгээр зүйлийн 2, 4-т заасан соёлын болон байгалийн өвийг хамгаалах, хадгалах, сэргээн засварлах болон сурталчлахын тулд урлаг, шинжлэх ухаан, техникийн асуудлаар судалгаа хийх,
- б) Батлагдсан төслийг хангалттай хэрэгжүүлэхийн тулд шинжээч, техникч болон мэргэжилтэй ажилчдыг илгээх,
- в) Соёлын болон байгалийн өвийг илрүүлэх, хамгаалах, сэргээн засварлах болон сурталчлах ажлын мэргэжилтнүүдийг бүх түвшинд бэлтгэх,
- г) Сонирхогч улсад байхгүй буюу олж авах боломжгүй тоног төхөөрөмжийг өгөх,
- д) Удаан хугацаагаар бага хүүтэй буюу хүүгүй зээл олгох,
- е) Онцгой тохиолдолд буюу тусгай шалтгаанаар буцалтгүй мөнгөн тусламж олгох,

Хорин гуравдугаар зүйл

Дэлхийн өвийн хороо соёлын болон байгалийн өвийг илрүүлэх, хамгаалах, хадгалах, сэргээн засварлах болон сурталчлах ажлын мэргэжилтнүүдийг бүх түвшинд бэлтгэх үндэсний болон бүсийн төвүүдэд олон улсын тусламж үзүүлэх болно.

Хорин дөрөвдүгээр зүйл

Олон улсын том хэмжээний тусламж олгохдоо урьдчилан шинжлэх ухаан, эдийн засаг, техникийн нарийвчилсан судалгаа хийнэ. Энэхүү судалгааг явуулахдаа байгалийн болон соёлын өвийг хамгаалах, хадгалах, сэргээн засварлах болон сурталчлах талаар тэргүүний аргыг ашиглах бөгөөд тэрхүү судалгаа нь энэхүү Конвенцийн зорилготой нийцэж байх шаардлагатай. Уг судалгаанд сонирхогч улсуудын бэлэн байгаа хөрөнгийг оновчтой ашиглах арга замыг мөн тодорхойлох ёстой.

Хорин тавдугаар зүйл

Зарчмын хувьд шаардлагатай ажлын санхүүжилтийн зөвхөн нэг хэсэг нь Олон улсын хамтын нийгэмлэгт ногдох ёстой. Хэрэв нөөц хөрөнгө нь хүрэлцээтэй бол төлөвлөгөө төсөл бүрд зориулсан хөрөнгийн гол хэсгийг олон улсын тусламж авч буй улсын санхүүгийн оролцоо бүрдүүлэх ёстой.

Хорин зургадугаар зүйл

Энэхүү Конвенцийн дагуу төлөвлөгөө, төслийг хэрэгжүүлэхэд олгох олон улсын тусламж Дэлхийн өвийн хороо болон тусламж авагч улсын хооронд байгуулсан хэлэлцээрт тодорхойлсон нөхцлийн үндсэн дээр шийдэгдэх ёстой. Олон улсын тусламж авах улс байгуулсан хэлэлцээрт тодорхойлсон нөхцлийн дагуу холбогдох үнэт зүйлийг хамгаалах, хадгалах болон сурталчлах ажлыг үргэлжлүүлэх хариуцлага хүлээнэ.

Зургаа боловсролын хөтөлбөрүүд

Хорин долдугаар зүйл

1. Энэхүү Конвенцид нэгдсэн орнууд Конвенцийн 1, 2 дугаар зүйлд заасан соёлын болон байгалийн өвийг өөрийн ард түмнээр хүндэтгэн хамгаалуулахыг бүхий л зохистой аргаар тухайлбал, боловсрол, мэдээллийн хөтөлбөрийг ашиглан хэрэгжүүлэхийг эрмэлзэнэ.

2. Энэхүү өвд учирч буй аюул заналын тухай болон энэ Конвенцийг дагаж мөрдөх талаар авч буй арга хэмжээнийхээ тухай олон нийтэд өргөнөөр мэдээлж байх үүрэг мөн хүлээнэ.

Хорин наймдугаар зүйл

Энэхүү Конвенцийн дагуу олон улсын тусламж авч буй Конвенцид нэгдэгч орнууд тусламж авсан өвийн чухал ач холбогдол болон уг тусламжийн гүйцэтгэсэн үүргийг мэдээлэхийн тулд холбогдох арга хэмжээг авч байна.

Долоо. Тайлан илтгэлүүд

Хорин есдүгээр зүйл

1. Энэхүү Конвенцид нэгдэгч улсууд Нэгдсэн Үндэстний Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллагын Ерөнхий бага хурлаас заасан хугацаа, хэлбэрийн дагуу тус бага хуралд гаргаж өгөх илтгэлдээ энэхүү Конвенцийг хэрэгжүүлэх зорилгоор гаргасан хууль тогтоомжийн заалтуудын тухай болон авсан бусад арга хэмжээнийхээ тухай мөн энэ салбарт хуримтлуулсан туршлагын тухай мэдээлж байна.

2. Эдгээр илтгэлийг Дэлхийн өвийн хорооны сонорт хүргэнэ.

3. Хороо нь Нэгдсэн Үндэстний Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллагын Ерөнхий бага хурлын ээлжит чуулган бүр дээр өөрийн үйл ажиллагааны тухай тайлан илтгэл тавина.

Найм төгсгөлийн заалтууд

Гучдугаар зүйл

Энэхүү Конвенцийн англи, араб, испани, франц, орос хэлээр үйлдсэн бүх 5 эх бичвэр нь адил хүчинтэй байна.

Гучин нэгдүгээр зүйл

1. Энэхүү Конвенцийг Нэгдсэн Үндэстний Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллагын гишүүн улсууд өөрсдийн үндсэн хуулиар тогтоогдсон журмын дагуу соёрхон батлах буюу баталж болно.

2. Соёрхон баталсан жуух бичиг буюу баталсан тухай баримт бичгийг Нэгдсэн Үндэстний Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллагын Ерөнхий Захиралд хадгалуулна.

Гучин хоёрдугаар зүйл

1. Энэхүү Конвенцид тус байгууллагын Ерөнхий бага хурлаас тус Конвенцид нэгдэхийг урьсан урилга хүлээн авсан Нэгдсэн Үндэстний Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллагын гишүүн бус ямар ч улс нэгдэн орж болно.

2. Нэгдэж орсон тухай баримт бичгийг Нэгдсэн Үндэстний Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллагын Ерөнхий Зөхиралд хадгалуулснаар Конвенцид нэгдсэнд тооцогдоно.

Гучин гуравдугаар зүйл

Энэхүү Конвенц нь соёрхон баталсан, баталсан буюу нэгдэн орсон тухай 20 дахь батламж жуух бичиг болон баримт бичгийг хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш 3 сарын дараа хүчин төгөлдөр болох бөгөөд заасан өдөр буюу түүнээс өмнө соёрхон баталсан, баталсан буюу нэгдэж орсон тухай баримт бичгээ хадгалуулсан улсуудын хувьд л хүчин төгөлдөр болно. Бусад аливаа улсын хувьд Конвенцийг соёрхон баталсан, баталсан буюу нэгдэж орсон тухай баримт бичгээ хадгалуулсан өдрөөр хойш 3 сарын дараа хүчин төгөлдөр болно.

Гучин дөрөвдүгээр зүйл

Энэхүү Конвенцид нэгдэн орсон холбооны байгуулал бүхий улсуудад дараах заалт хамаарна. Үүнд:

а) Энэ Конвенцийн заалтуудын хэрэгжилт төв буюу холбооны хууль тогтоох засгийн хууль тогтоох үйл ажиллагаанд хамаарагдаж байх нөхцөлд холбооны буюу төв засгийн газрын үүрэг нь Конвенцид нэгдсэн холбооны бус байгуулалтай улсынхаа адил байна.

б) Энэхүү Конвенцийн заалтуудын хэрэгжилт нь холбооны системийн дагуу хууль тогтоох арга хэмжээ авах үүрэггүй муж улс, муж, зантон бүрийн хууль тогтоох үйл ажиллагаанд хамаарагдаж байх нөхцөлд холбооны засгийн газар нь дурдсан заалтуудыг

батлах зорилгоор тэдгээр муж, улс, муж кантоныуудын эрх бүхий байгууллагуудад тэдгээрийн тухай мэдээлнэ.

Гучин тавдугаар зүйл

1. Энэхүү Конвенцид оролцогч ямар ч улс уг Конвенцийг цуцулж болно.

2. Конвенцийг цуцалсан тухай баримт бичгийг Нэгдсэн Үндэстний Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллагын Ерөнхий Захиралд гардуулж цуцалснаа мэдэгдэнэ.

3. Цуцлах тухай баримт бичгийг хүлээн авснаас хойш 12 сарын дараа тийнхүү цуцалсан нь хүчин төгөлдөр болно. Конвенциос гарч буй улсуудын санхүүгийн талаар хүлээсэн үүрэг цуцлалт хүчин төгөлдөр бөөлөх өдрийг хүртэл хэрхэвч өөрчлөгдөхгүй.

Гучин зургадугаар зүйл

Нэгдсэн Үндэстний Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллагын Ерөнхий Захиралд соёрхон баталсан, баталсан буюу нэгдэж орсон тухай 31, 32 дугаар зүйлд дурдсан бүх баримт бичгийг хадгалуулахаар өгсөн тухай байгууллагын гишүүн улсуудад болон 32 дугаар зүйлд дурдсан Байгууллагын гишүүн бус улсуудад, түүнчлэн Нэгдсэн Үндэстний Байгууллагад мэдээлнэ.

Гучин долдугаар зүйл

1. Энэхүү Конвенцийг Нэгдсэн Үндэстний Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллагын Ерөнхий бага хурлаар дахин хянан үзэж болно. Гэхдээ Конвенцийн шинэчилсэн эх нь шинэчилсэн Конвенцид нэгдсэн улсуудын хувьд л хамаарна.

2. Хэрэв энэхүү Конвенцийг бүхэлд нь буюу хэсэгчлэн шинэчилсний дүнд Ерөнхий бага хурлаас шинэ Конвенц баталсан тохиолдолд мөн шинэ Конвенцид өөр заалтууд ороогүй бол шинэчилсэн Конвенц хүчин төгөлдөр болох өдрөөс эхлэн энэхүү Конвенц соёрхон батлах, батлах буюу нэгдэж ороход хаалттай байх болно.

Гучин наймдугаар зүйл

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрмийн 102 дугаар зүйлийн заалтын дагуу Нэгдсэн Үндэстний Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллагын Ерөнхий Захирлын хүсэлтээр Конвенцийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Нарийн бичгийн дарга нарын газарт бүртгүүлнэ.